



БАЯНХОНГОР АЙМГИЙН
БАЯНЛИГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 17 өдөр

Дугаар 4/61

Хатан суудал

Бүх нийтийн цэвэрлэгээ
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.6, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4.1, 9.4.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Бүх нийтийн цэвэрлэгээг хогийн цэгээс Нүдэнгийн овгор хүртэл байгууллагуудын албан хаагчдыг, орчны цэвэрлэгээнд айл өрх, аж ахуйн нэгж, дэлгүүр, шатахуун түгээх станцуудыг хамруулан 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 15-18 цагийн хооронд тус тус зохион байгуулсугай.

2. Цэвэрлэгээний явц болон аж ахуй нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Цэвэлмаа), Газрын даамал (М.Мэндхүү), Байгаль хамгаалагч (Б.Галдан), Хатан суудал 5 дугаар багийн Засаг дарга (Б.Амаржаргал) нарт, нийтийн цэвэрлэгээний өдөр сумын төвд байгаа айл өрхүүдээ идэвхтэй хамруулахыг багийн Засаг дарга (С.Баттулга), (Ц.Намхайхорол), (А.Элдэв-Очир), (Д.Батаа) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Нийтийн цэвэрлэгээний өдөр үйлчилгээний цэг, аж ахуй нэгжүүдийг 15-18 цагийн хооронд ажиллуулахгүй байхыг Экологи хариуцсан байцаагч (Г.Сандаг-Очир) албан байгууллага, аж ахуй нэгж, үйлчилгээний газрууд үйл ажиллагаандаа цагийн зохицуулалт хийж, албан хаагчдаа бүрэн хамруулахыг аж ахуйн нэгж байгууллагын дарга, эрхлэгч нарт тус тус үүрэг болгосугай.

4. Цэвэрлэгээнд оролцсон болон оролцоогүй иргэд, аж ахуйн нэгж байгууллагыг гарын үсгээр баталгаажуулан бүртгэж Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Ц.Цэвэлмаа)-д 2024 оны 05 дугаар сарын 17-ны өдөр хүлээлгэн өгөхийг байгууллагын Бичиг хэргийн ажилтнуудад даалгасугай.

842401093

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Г.Мөнхсүх)- д даалгасугай.

ДАРГА  О.МӨНХБАТ

